

КОМПАНИЙН АШИГТ АЖИЛЛАГААНД ДОТООД АУДИТЫН ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛЛИЙН ШИНЖИЛГЭЭ

Б.Балжинням*, Д.Сувдаа**, С.Батбилэг***

Хураангуй: Энэхүү судалгаагаар үндэсний компаниудын дотоод аудитын чанарыг тодорхойлж, дотоод аудитын чанар компанийн ашигт ажиллагаанд үзүүлэх нөлөөллийг судалж, үнэлэлт дүгнэлт өгсөн. Компанийн дотоод аудитын чанарыг 54 компанийн төлөөлөл бүхий дотоод аудит, хяналтын ажилтнууд болон мөн эдгээр компанийн дотоод аудитын бус ажилтнуудаас анкет асуулгын аргаар авсан. Дотоод аудитын ажилтнууд дотоод аудитын чанараа өндөр үнэлдэг ч, карьер хөгжлийн асуудал болон ажилтнуудын үнэлэмж, дэмждэг соёлд сэтгэл хангалуун бус байна. Дотоод аудитын чанарын үзүүлэлт ба компанийн ашигт ажиллагааны (ROA) хооронд эерэг хамааралтай буюу дотоод аудитын чанарын үзүүлэлт 1 нэгжээр өсөхөд компанийн ашигт ажиллагаа 1.7 нэгж хувиар нэмэгддэг гэсэн тооцоо нь зөвхөн дотоод аудитын хөгжлийг дэмжих үндэслэл төдийгүй, компаниудын улсын эдийн засгийн оруулах хувь нэмрийг нэмэгдүүлэх арга зам болно гэдгийг харуулж байна.

Түлхүүр үгс: Дотоод хяналт, Агентын онол, Дотоод аудитын чанарын үнэлгээ, хөрөнгийн өгөөж (ROA)

ANALYSIS OF THE IMPACT OF INTERNAL AUDIT ON COMPANY PROFITABILITY

Abstract: This study identifies the quality of internal audits in national companies and examines and evaluates the impact of internal audit quality on company profitability. The quality of internal audit in companies was obtained through a questionnaire survey from internal audit and control personnel, as well as non-internal audit personnel from these companies, representing 54 companies. Although internal audit personnel highly value the quality of their internal audit, they are not satisfied with the career development issues and the culture in which employees are valued and supported. The positive correlation between internal audit quality indicators and company profitability (ROA) is estimated to be 1.7 percentage points higher when the internal audit quality indicator increases by 1 point, indicating that it is not only a reason to support the development of internal audit, but also a way to increase the contribution of companies to the national economy.

Keywords: Internal control, Agent theory, Internal audit quality assessment, return on assets (ROA)

* Монголросцветмет ТӨҮГ, (E-mail): baljaa2022@gmail.com

** МУИС, Бизнесийн сургууль, (E-mail): d.suvdaa@num.edu.mn

*** МУИС, Мэдээллийн Технологи, Электроникийн Сургууль, (E-mail): batbileg_sh@num.edu.mn

Удиртгал

Сүүлийн жилүүдэд аж ахуйн нэгж, байгууллагад дотоод хяналт, аудитын эрэлт өсөж, компанид дотоод аудитын алба, нэгж өргөжиж тэлсээр байна. Дотоод аудитын алба, нэгжүүдийн өргөжин тэлж буй нь компаниудын удирдлагын системд дотоод хяналтын ач холбогдол өсөн нэмэгдэж байгааг харуулж байна. Аж ахуйн нэгж, байгууллагууд зах зээлд өрсөлдөх чадвараа хадгалахын тулд дотоод хяналтын тогтолцоогоо сайжруулах шаардлагатай болж байна. Иймд Монголын компаниудын дотоод аудитын чанарт дүгнэлт өгөх, ашигт ажиллагаанд оруулж буй хувь нэмрийг таньж мэдэх хэрэгцээ шаардлага байна.

Монгол Улсад төрийн болон дотоод аудитын чиглэлээр хэд хэдэн судалгаа хийгдсэн байдаг. Сүүлийн 10 гаруй жилийн хугацаанд дотоод аудитын мэргэжилтнүүд хамтран “IIA Chapter Mongolia” мэргэжлийн холбоог байгуулж, тогтмол сургалт зохион байгуулахын зэрэгцээ жил бүр нэгдсэн форум зохион байгуулж, шинэ мэдлэг, туршлага, ололт амжилтаа хуваалцсаар байна. Дотоодын судлаачдын хувьд дараах судалгааны ажлууд хийгдсэн байна.

1. А.Өнөржаргал 2014 онд “Компанийн дотоод аудитын онол, арга зүйн асуудал” бүтээлдээ Монгол Улсын компаниудад дотоод аудитын эрэлт бий болох шалтгаануудыг хууль эрх зүйн шаардлага, засаглах болон гүйцэтгэх удирдлагын зааглалт, олон хувьцаа эзэмшигчтэй байх, нийтийн ашиг сонирхлыг хөндсөн үйл ажиллагаа эрхлэх, бизнесийн өргөжилт зэрэг хүчин зүйлсийн хүрээнд судалжээ. Энэхүү судалгаанд үндэсний 25 компани хамрагдсан байна.
2. Д.Батбаяр 2021 онд “Дотоод аудит” бүтээлд дотоод аудитын үндсэн зарчим, бүтэц зохион байгуулалт, аудитын төлөвлөгөө, гүйцэтгэл, тайлагналын жишгийг тодорхойлсон байдаг.

Эдгээр судалгааны бүтээлүүд нь Монгол Улсад дотоод аудитын онол, арга зүй, практик хэрэглээний талаарх анхны иж бүрэн судалгааны жишээнүүдийн нэг болж байгаа нь чухал ач холбогдолтой юм.

Мөн дотоод аудитын чанар болон компанийн ашигт ажиллагааны уялдаа холбоог судалсан дараах гадаад судалгаануудыг онцлон дурдъя:

1. Catherine Cherono Bett (2014), “The relationship between the effectiveness of internal audit function and financial performance of companies listed in Nairobi securities exchange”.

Энэ судалгаанд Найроби хөрөнгийн биржид бүртгэлтэй 61 компанийн дотоод аудитын үр нөлөөг анкет асуулгын аргаар үнэлж, дотоод аудитын чанарын үзүүлэлт болон ROA хооронд шугаман регресс шинжилгээ хийсэн байна.

2. Nankunda Sharon (2013), “Internal audit function and financial performance of public sector organizations: a case of national water and sewerage corporation - Mbarara branch”

Энэхүү судалгаанд Үндэсний ус, ариутгах татуургын салбарын төрийн байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудитын нөлөөллийг шинжилжээ. Судалгаанд 50 компанийн ажилтнуудыг хамруулан, асуулгын үр дүн болон ROA хооронд Pearson-ийн корреляцийн шинжилгээ хийсэн байна.

Бидний энэ судалгааны ажлын зорилго нь Үндэсний компаниудын дотоод аудитын чанарыг нэгтгэн тодорхойлж, чанарт нөлөөлөх үзүүлэлтүүдийг шинжилж, дотоод аудитын чанар компанийн ашигт ажиллагаанд үзүүлэх нөлөөллийг судалж, үнэлэлт дүгнэлт өгөхөд оршино.

Энэхүү судалгааны ажлын аргачлал нь олон улсын хүлээн зөвшөөрөгдсөн практикийн дагуу хийгдсэн бөгөөд аудитын чанарын үзүүлэлтийг бодитоор үнэлэх, ашигт ажиллагаатай холбогдох хамаарлыг илүү нарийвчлалтай тодорхойлох, компанийн дотоод аудитын чанар болон компанийн ашигт ажиллагааны хоорондын уялдаа, нөлөөллийг судлан тогтоох ач холбогдолтой юм.

Энэхүү судалгаа дараах хэд хэдэн чиглэлд үнэ цэнтэй байна. Үүнд:

- Дотоод аудитын үр нөлөөг тоон үзүүлэлтээр тодорхойлох / Судалгаанд анкет асуулгын аргаар дотоод аудитын чанарыг хэмжиж, компанийн ашигт ажиллагаа (ROA)-д үзүүлэх нөлөөллийг регрессийн шинжилгээгээр тооцоолсон нь дотоод аудитын чанарыг бодит, тоон үндэслэлтэйгээр үнэлэх боломжийг бүрдүүлж байна./
- Дотоод аудитын чанар байгууллагын ашигт ажиллагаанд үзүүлэх нөлөөг таньж мэдсэнээр компаниудын удирдлага, хувьцаа эзэмшигчдэд аудитын үр өгөөжийг ойлгуулахад дэмжлэг үзүүлнэ./
- Судалгааны дүн нь дотоод аудитын талаарх Монголын компаниудын туршлага, тулгамдсан асуудлуудыг оновчтой тодорхойлж, цаашдын судалгаа, мэргэжлийн хандлагыг тодорхойлоход дэмжлэг болно.

Иймд энэ судалгааны ажил нь зөвхөн академик шинж чанартай төдийгүй дотоод аудитын чанарыг сайжруулах, байгууллагын ашигт ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, олон улсын стандартад нийцсэн аудитын тогтолцоог хөгжүүлэхэд хувь нэмэр оруулах ач холбогдолтой гэж зохиогчийн зүгээс үзэж байна.


Дотоод аудитын онолын үндэслэл, чанарыг үнэлэх аргачлал

1. Байгууллагын хяналтын тогтолцоо

Байгууллагын хяналтын тогтолцоог бүрдүүлдэг гол хяналтууд болох дотоод хяналт, комплайнс болон дотоод аудитын эцсийн зорилго, хүрэх үр дүн нь нэг боловч эдгээр хяналтыг хэрэгжүүлэх арга зам, чиг үүрэг, удирдлага зохион байгуулалт нь өөр хоорондоо зарчмын хувьд ихээхэн ялгаатай. “Базелийн хороо”-ноос эдгээр хяналтын чиг үүргийг тусгаарлах, бодлого журмыг тус тусад нь боловсруулах, хяналтыг хэрэгжүүлэх тусдаа нэгж, ажилтантай байхыг зөвлөсөн байдаг.

Байгууллагын үйл ажиллагааны хамгаалалтын буюу эрсдэлийг удирдах 3 үе шат байна. Дотоод хяналт, комплайнс болон дотоод аудит нь эдгээр үе шатанд хуваагдаж хяналтын чиг үүргүүдээ гүйцэтгэж байдаг.

Зураг 1. Байгууллагын үйл ажиллагааны хамгаалалтын үе шат



Эх сурвалж: СЭХ, Байгууллагын хяналтын тогтолцооны гарын авлага, 2021

Дээрх зургаас үзэхэд хяналтууд нь өөр өөр хамгаалалтын үе шатанд хуваагдаж чиг үүргийн болон хэрэгжүүлэх цаг хугацааны хувьд ялгаатай тул дотоод хяналт, комплайнс болон дотоод аудитын үйл ажиллагааг нэг нэгж, нэг ажилтнаар гүйцэтгүүлэх нь зарчмын болон ашиг сонирхлын зөрчлийн хувьд нийцэхгүй аж.

Дотоод хяналт: Байгууллагын хариуцлагатай, ил тод, үр дүнтэй байдал нь гүйцэтгэх захирлын зүгээс байгууллагын бүхий л үйл ажиллагааг хамарсан дотоод хяналтын системийг хэрхэн бүрдүүлснээс шууд хамаардаг. Дотоод хяналт гэдэг нь тухайн байгууллага хууль тогтоомж, дүрэм журмыг даган мөрдөж,

тэдгээрт нийцэж буй байдал, санхүүгийн үнэн зөв тайлагнал, үйл ажиллагааны төлөвлөгөө болон үр ашигт байдлаа дээшлүүлэх, менежментийн бодлогын хэрэгжилт зэргийг хангуулахад чиглэсэн нягтлан шалгах үйл ажиллагаа бөгөөд байгууллагын төлөөлөн удирдах зөвлөл /ТУЗ/, гүйцэтгэх болон нэгжийн удирдлага, ажилтан бүрийн оролцоотойгоор хэрэгждэг байнгын шинж чанартай, тасралтгүй үргэлжлэх цогц үйл явц юм.

Үйл ажиллагааны онцлог, цар хүрээ, салбарын тоо, бүтэц, нийт ажилтнуудын тоо зэргээс хамааран дотоод хяналтын нэгжийг байгуулах, эсхүл ажилтанг томилно. Үр дүнтэй дотоод хяналтын системийг бий болгох зарчмууд хангагдаж байгаа эсэхийг үнэлнэ. Дотоод хяналтын нэгж/ажилтан - гүйцэтгэх удирдлагын шууд удирдлага дор байрлаж, гүйцэтгэх удирдлагаас өгсөн чиглэлээр дотоод хяналтыг хэрэгжүүлж, мөн гүйцэтгэх удирдлагад тайлагнана.

Бусад шатны удирдлага ба ажилтнууд — Дотоод хяналтыг зөвхөн гүйцэтгэх удирдлага, эсхүл томилогдсон нэгж/ажилтан хэрэгжүүлнэ гэдэг нь өрөөсгөл ойлголт ба байгууллагын нэгж, ажилтан бүр үйл ажиллагаандаа дотоод хяналтыг хэрэгжүүлэн ажиллах нь зүйтэй. Дотоод хяналтаар хүлээсэн үүргээ биелүүлж, дотоод хяналтын системийг илүү сайжруулах талаар санал, санаачилга гарган ажиллах нь зохистой.

Дотоод аудит: Дотоод Аудиторуудын Олон Улсын Институтээс гаргасан Дотоод Аудитын Мэргэжлийн Практикийн Олон Улсын Стандартад “Дотоод аудит гэж байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, түүний үнэ цэнийг нэмэгдүүлэхэд чиглэсэн хараат бус, бодитой баталгаа өгөх ба зөвлөх үйл ажиллагаа юм” гэж тодорхойлсон.

Дотоод аудитын нэгж нь дотоод хяналтын үр ашигт байдалд үнэлгээ хийх, тэдгээрийн байнгын сайжруулалтад дэмжлэг үзүүлэх замаар үр нөлөөтэй дотоод хяналтын системийг бий болгоход байгууллагад тусалцаа үзүүлнэ. Дотоод аудит нь байгууллагад үүссэн алдаа зөрчлийг олж илрүүлэн тайлагнахаас гадна компанийн засаглал ба гүйцэтгэх удирдлагын чиг үүрэг, эрх мэдэл, үүрэг хариуцлага, тулгарч буй, эсхүл болзошгүй эрсдэлийг зохистой удирдаж байгаа эсэх, дотоод хяналтын тогтолцоог оновчтой бүрдүүлсэн эсэхийг тодорхойлж, эдгээр үйл ажиллагааг сайжруулахад чиглэнэ.

2. Дотоод аудитын онол

Англид 1881 онд Ф.Пиксли, 1892 онд Л. Дикси, Т.Рууд нар аудитын онол, арга зүйн асуудлаар шинжлэх ухааны анхны бүтээлүүдийг туурвисан байна. Эдгээр судлаачдын бүтээлийн гол үзэл санаа нь аудитын үндсэн зорилгыг байгууллагын эдийн засгийн үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн мэдээ

тайланд үнэн бодитоор тусгаж байгааг батлахад чиглэгдэнэ гэж үзэж байсан.


2.1. Хяналтын онол (*controlling theory*)

Дэлхийн эдийн засгийн их хямралын дараа дотоод хяналтын тогтолцоо сайтай байгууллагын санхүүгийн тайлан алдаа мадаг багатай байна гэж үздэг “хяналтын онол” (*controlling theory*)-ын үзэл баримтлал аудитад их дэлгэрч, аудитын зорилгыг зөвхөн санхүүгийн баримтын үнэн зөвийг баталгаажуулах бус харин байгууллагын дотоод хяналтыг шалгаж үнэлэх, түүнийг сайжруулах явдал гэж үзэх болсон. Ийнхүү 1940-өөд оноос удирдлагад төлөвлөлт, дотоод хяналт чухал үүрэгтэйг тодорхойлсон контроллингийн онолын үзэл баримтлал хүчтэй хөгжсөн, хөндлөнгийн аудитыг хуулиар шаардаж, хөндлөнгийн аудитаар байгууллагын дотоод хяналтын системийн үр ашгийг үнэлэх болсон зэрэг нь удирдлагын зүгээс дотоод хяналтаа сайжруулахыг эрэлхийлэхэд хүргэж, аудитын нэг төрөл болох дотоод аудитын чиг үүргийг нэмэгдүүлэн, түүнийг хөгжүүлэхэд шийдвэрлэх нөлөө үзүүлжээ.

2.2. Агентын онол (*Agency theory*)

Аудит үүсэх болсон хэрэгцээ шаардлага, аудитын мөн чанар, зориулалтыг “Агентын онол”, ялангуяа түүний эзэн-агентын харилцааны үндэслэлүүдийг ашиглан тайлбарлаж болдог. Агентын онол (*Agency Theory*) нь “эзэн” (*Principal*) хэмээх нэг тал “агент” (*Agent*) хэмээх нөгөө талд эдийн засгийн нөөцөө хадгалж хамгаалах, захирах, ашиглах эрхийг шилжүүлэхтэй холбоотой харилцааг судалдаг. Гол асуудал нь агент зохих ёсоор ажилласан эсэхийг эзэн магадлах боломжгүй байдагт оршино. Хоёр дахь нь эрсдэлээ хуваалцах асуудал бөгөөд эзэн ба агент эрсдэлийн талаар өөр өөр хандлагатай байх үед үүсдэг. Мөн агенттай холбоотой хоёр эрсдэл байнга тулгардаг. Гэрээг анх байгуулахаас өмнө агентыг сайн судалж мэдээгүй байснаас хийж чадахгүй байх эрсдэл бий. Гэрээ нэгэнт байгуулагдсаны дараа ч агентын үйл хөдлөл, ажлын гүйцэтгэлийг байнга ажиглаж хянах боломж муу. Өөрөөр хэлбэл, агентыг буруу сонгох (*adverse selection*) болон тэдний мөс жудаг (*moral hazard*)-аас үүдэх асуудал гарч болно.


Зураг 2. Эзэн-агентын харилцааны загвар



Эх сурвалж: http://en.wikipedia.org/wiki/Principal-agent_problem.

Эзэн-агентын харилцааны ээдрээ төвөгтэй байдлаас аудитын хэрэгцээ шаардлага урган гарсан гэж үздэг. Эзэн агентын хоорондын мэдээллийн тэнцвэргүй байдал, сонирхол, сэдлийн ялгаанаас болоод эзэн агентдаа итгэж чадахгүй байж болох бөгөөд итгэлийг дээшлүүлэх үүднээс аудит гэх мэт механизмыг нэвтрүүлсэн гэж үздэг. Агент өөрийнх нь сонирхлыг бүрэн төлөөлж байгаа эсэхийг эзэн сайтар хянаж шинжлэх боломжгүй байвал агентын үйл ажиллагааны талаар хараат бус үнэлгээ хийлгэхийн тулд хөндлөнгийн этгээд (жишээлбэл, аудитор)-ийн туслалцааг эрэлхийлэх хэрэгцээ гарч ирнэ. Менежер (агент)-ийн зүгээс ч бүхий л зүйлийг нууж хаалгүй үнэн зөв, шударга илтгэж тайлагнасан гэдэгт өмчлөгч (эзэн)-ийг итгүүлэх хэрэгцээ шаардлага бий. Миний тайлан үнэн зөв, алдаа мадаггүй, шударга, бодитой гэж дан ганц өөрөө тайлбарлах нь итгэл үнэмшил муутай. Харин өөрөөс нь хараат бус, мэргэжлийн этгээд (аудитор) хөндлөнгөөс нь шалгаад, байдлыг яг бодитой байгаагаар нь хэлж өгвөл өмчлөгч (эзэн)-ийн итгэл үнэмшил дээшилнэ. Агент санаатай буюу санамсаргүй байдлаар бүх мэдээллээ үнэн зөв, шударга мэдээлэхгүй байх эрсдэл бий. Тиймээс ч “санхүүгийн тайлангийн хэрэглэгчдэд зориулсан мэдээллийн эрсдэлийг хүлээн зөвшөөрөгдөх түвшинд хүртэл бууруулах үйл явцыг аудит” гэж үздэг.

Зураг 3. Эзэн-агент-аудиторын 3 талт харилцаа



Эх сурвалж: Б.Батбаяр. Дотоод аудит, 2021

Менежер (агент) өмчлөгч (эзэн)-ийнхөө итгэлийг хүлээж чадвал, хөрөнгө нөөцийг нь цааш үргэлжлүүлэх захиран зарцуулах нөхцөл бүрдэнэ. Хувьцаат компанийн гүйцэтгэх удирдлага хувьцаа эзэмшигчид, удирдах зөвлөлийнхөө итгэлийг алдахгүй байх, бизнесийн бусад байгууллага хэрэглэгч, үйлчлүүлэгчдээ алдахгүй байхыг хүснэ. Эс тэгвээс тэдний ашиг орлого буурна. Төрийн байгууллага төрөөс даалгасан буюу хуулиар хүлээлгэсэн ажил, үүргийг зохих ёсоор хийж гүйцэтгэсэн гэж дээд байгууллага, удирдлагадаа үнэлэгдэхийг хичээнэ. Тиймээс нэг талаас, бусад төлөөлүүлэн хариуцуулсан хөрөнгө нөөцийнхөө хадгалалт, хамгаалалт, ашиглалт, зарцуулалтыг хянах гэсэн өмчлөгч (эзэн)-ийн хүсэл сонирхол, нөгөө талаас, бусдын итгэлийг олж авч, тогтоон барих гэсэн менежер (агент)-ийн хэрэгцээ шаардлагын дагуу аудит хийлгэдэг гэж дүгнэж болно. Өөрөөр хэлбэл, аудитын үйлчилгээ бол шалгуулж байгаа тал, шалгагдагч талын аль алиных нь бодит хэрэгцээнд тулгуурладаг. Эрэлт хэрэгцээ байвал хангалт, нийлүүлэлт аяндаа үүснэ.

3.МУ-ын дотоод аудитын эрх зүйн орчин

Манай улсад арилжааны банкуудад анхны дотоод аудитын алба үүссэн

бөгөөд 2010 оноос хойш эрх зүйн орчны зарим элементүүд бүрдэж, үндэсний томоохон компаниудад дотоод аудит бий болох үйл явц эрчимтэй явагдаж байна.

Хүснэгт 1. Дотоод аудит, хяналтын талаар зохицуулсан хууль, эрх зүйн акт

Хууль	Хуулийн заалт
Төсвийн тухай хууль	11 дүгээр зүйл.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний бүрэн эрх 11.1.11.төсөв, санхүүгийн дотоод аудит, хяналт шалгалтыг зохион байгуулж, удирдлагаар хангах; 12 дугаар зүйл.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх 12.1.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 12.1.16.төсвийн дотоод аудит, хяналт шалгалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх; 16.5.Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 16.5.6.дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх; 69 дүгээр зүйл.Дотоод аудит 69.1.Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна. 69.2.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод аудитын албыг үйл ажиллагааны стандарт, арга зүйн удирдлагаар хангана. 69.3.Дотоод аудитад төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн санхүүгийн үйл ажиллагааг хамаарна.
Төрийн аудитын тухай хууль	4.1.4."шалгагдагч этгээд" гэж төсвийн байгууллага, тусгай сан, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд, төрийн чиг үүргийг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр шилжүүлэн авсан этгээд болон хуульд заасны дагуу төрийн аудит хийгдэх аливаа этгээдийг; 9.2.Төрийн аудитын байгууллага шалгагдагч этгээдийн тогтолцоо, үйл ажиллагааны зохион байгуулалт, түүний хэмжилт, дотоод хяналт үр нөлөөтэй эсэхэд дүгнэлт өгч, тэдгээрийг сайжруулах чиглэлээр гүйцэтгэлийн аудит хийнэ.

Компанийн тухай хууль	2 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ 2.1.Хуульд өөрөөр заагаагүй бол Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа бүх компани өмчийн хэлбэр, эд хөрөнгийн болон үйлдвэрлэлийн хэмжээ, дотоод зохион байгуулалтаас үл хамааран энэ хуулийг дагаж мөрдөнө. 81 дүгээр зүйл.Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороо 81.4.1.компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийг олон улсын стандартад нийцүүлэх, дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа, санхүүгийн тайлан, санхүү, эдийн засгийн бусад мэдээллийн үнэн бодит байдалд хяналт тавих; 81.4.2.дотоод хяналтын албаны удирдлага, ажилтныг томилох, цалин, урамшууллыг тогтоох санал боловсруулах;
Банкны тухай	31 дүгээр зүйл.Банкны төлөөлөн удирдах зөвлөл 31.3.6.банкны дотоод аудитын нэгжийг гүйцэтгэх удирдлагаас хараат бусаар зохион байгуулж, түүний төсөв, орон тоог батлах, удирдлага, ажилтныг томилох, үйл ажиллагааны журмыг тогтоох, цалин, урамшууллын хэмжээг тогтоох; 31.3.8.банкны нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын тогтолцоо, хөндлөнгийн болон дотоод аудит, эрсдэлийн удирдлага, санхүүгийн болон үйл ажиллагааны хяналт, хууль тогтоомж, стандартын хэрэгжилтийг хамарсан зохистой хяналтын тогтолцоог бүрдүүлэх; 31.7.Банкны дотоод аудитын нэгж нь банкны бодлого, тухайн жилийн бизнес төлөвлөгөө, төсөв, үйл ажиллагаанд мөрдөх журмын хэрэгжилт, нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, санхүүгийн тайлан зөв эсэхэд хяналт тавьж, актив хөрөнгийг хамгаалан үр ашгийг дээшлүүлэх чиг үүрэгтэйгээр банкны төлөөлөн удирдах зөвлөлд ажлаа тайлагнах зарчмаар ажиллана.
Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль	66 дугаар зүйл. Хяналт шалгалтын тогтолцоо 1. Төрийн өмчийн эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, эзэмшилт, ашиглалт, захиран зарцуулалтад тавих төрийн хяналт шалгалт нь Улсын Их Хурал, Засгийн газраас тавих ерөнхий хяналт, Төрийн хянан шалгах хороо, Сангийн яам болон төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас хэрэгжүүлэх мэргэжлийн хяналт шалгалт, хуулийн этгээдийн дотоодын хяналт шалгалтаас бүрдэнэ. 67 дугаар зүйл. Дотоодын хяналт шалгалт 1.Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна.

Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолын хавсралт дотоод аудитын дүрэм	1. Энэхүү дүрэм нь төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн төвлөрүүлэн захирагч, төсвийн шууд захирагч бүрийн дотоод аудитын үйл ажиллагааны зорилго, хамрах хүрээ, зарчим, зохион байгуулалт, дотоод аудитор, санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагчийн эрх, үүргийг тодорхойлж, дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын үйл ажиллагааг явуулах, хөндлөнгийн аудитын байгууллагатай хамтарч ажиллахтай холбогдох харилцааг зохицуулна.
Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр Тогтоолын хавсралт Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам	1.2. Төрийн хяналт шалгалтад хамрагдах өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллага энэхүү нийтлэг журмыг дагаж мөрдөнө. 1.3. Аж ахуйн нэгж, байгууллага нь энэхүү нийтлэг журамд нийцүүлэн, өөрийн үйл ажиллагааны онцлогт тохирсон “Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам”-тай байна. 1.5. Энэхүү журмын 1.4-т зааснаас бусад тохиолдолд “Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам”-ыг тухайн байгууллага, аж ахуйн нэгж өөрөө баталж мөрдөнө. 2.2. Дотоод хяналт шалгалтын зорилго нь аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаа, үйлдвэрлэсэн болон борлуулж байгаа бараа, бүтээгдэхүүн, үзүүлж байгаа ажил, үйлчилгээ нь хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэр, эрх бүхий бусад байгууллага, албан тушаалтны болон өөрийн гаргасан шийдвэрт нийцэж байгаа эсэхэд аж ахуйн нэгж, байгууллагын хэмжээнд хяналт тавьж илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах, гэм буруутай этгээдэд хариуцлага хүлээлгэхэд чиглэнэ. 2.3. Дотоод хяналт шалгалтыг зохих удирдамж, төлөвлөгөөний дагуу гүйцэтгэж, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг бүрэн хамарсан байвал зохино. Гурав. Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нэгж, ажилтан, түүний эрх үүрэг 3.1. Энэхүү журмын 1.3-т заасан “Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам”-д өөрөөр заагаагүй бол дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах үүргийг тухайн аж ахуйн нэгж, байгууллагын захиргааны асуудал хариуцсан нэгж, ажилтан гүйцэтгэнэ. 3.2. Дотоод хяналт шалгалтын нэгж, ажилтан нь тухайн аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагад шууд захирагдах бөгөөд зохион байгуулалтын хувьд бусад бүтэц, нэгжээс хараат бус байна.

Эх сурвалж: Эрх зүйн мэдээллийн нэгдсэн сангаас шүүсэн судлаачийн тэмдэглэл

4. Дотоод аудитын чанарын үнэлгээний арга зүй

Компанийн дотоод аудитын чанарыг анкет асуулгын аргыг ашиглан тооцоолсон. Компанийн ашигт ажиллагаа, дотоод аудитын чанарын үзүүлэлт хооронд регрессийн шинжилгээ хийсэн. Компанийн дотоод аудитын чанарыг

үнэлэхэд анкет асуулгын арга нь өргөн хэрэглэгддэг. Энэхүү арга нь Олон Улсын Дотоод Аудиторуудын Институт (IIA)-аас гаргасан “Дотоод аудитын чанарын үнэлгээний заавар” (Quality Assessment Manual) болон бусад зөвлөмжид нийцсэн. IIA-ийн зөвлөмжид аудитын чанарыг дараах үндсэн зарчмуудаар үнэлэхийг зөвлөдөг. Үүнд:

1. Аудитын төлөвлөгөөний оновчтой байдал /Аудитын стратеги болон эрсдэлд суурилсан төлөвлөлтийг хэр зэрэг сайн хэрэгжүүлж байгааг үнэлэх.
2. Аудитын үйл ажиллагааны хараат бус байдал /Дотоод аудитын нэгж байгууллагынхаа удирдлага, бусад ажилтнуудаас хараат бус байдлыг хадгалж байгаа эсэхийг шалгах./
3. Мэргэжлийн ур чадвар, хөгжлийн боломж /Аудитын багийн мэргэжлийн чадавх, тасралтгүй хөгжлийн боломж, сургалт болон ур чадварын түвшнийг хэмжих./
4. Аудитын үр дүнгийн үр нөлөө /Аудитын үр дүн байгууллагын удирдлагын шийдвэр гаргалтад ямар нөлөө үзүүлж байгаа талаар үнэлэх./

Эдгээр үзүүлэлтийг анкет асуулгын аргаар цуглуулсан мэдээллээр дүгнэж, аудитын чанарын үзүүлэлтүүдийг тооцоолсон.

Компанийн ашигт ажиллагаа (жишээ нь, хөрөнгийн өгөөж буюу ROA) болон дотоод аудитын чанарын үзүүлэлтийн хоорондын уялдаа холбоог судлахад регрессийн шинжилгээ хамгийн түгээмэл ашиглагддаг арга юм. Энэ нь нэг үзүүлэлт нөгөөд хэрхэн нөлөөлж байгааг статистик аргаар нарийвчлан тодорхойлох боломжийг олгодог.

Дэлхийн аудитын стандартын (IIA) дагуу компанийн дотоод аудитын чанарын үнэлгээг байгууллагын санхүүгийн гүйцэтгэлтэй уялдуулан шинжлэх нь дараах шалтгаантай:

- ☐ Дотоод аудитын чанар сайжрахын хэрээр байгууллагын үйл ажиллагааны үр ашиг, санхүүгийн өгөөж нэмэгдэх магадлал өндөр байдаг.
- ☐ Хариуцлагатай удирдлагын тогтолцоог дэмжих
- ☐ Аудитын үр дүнг үндэслэн байгууллагын үйл ажиллагааны эрсдэлүүдийг бууруулах, оновчтой шийдвэр гаргах боломж бүрдэнэ.

Асуулгын үр дүнг регрессийн шинжилгээнд оруулснаар дотоод аудитын чанар болон компанийн ROA хоорондын хамаарал, нөлөөллийн цар хүрээг тоон хэлбэрээр тодорхойлох боломжтой.

КОМПАНИЙН АШИГТ АЖИЛЛАГААНД ДОТООД
АУДИТЫН ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛЛИЙН ШИНЖИЛГЭЭ

1. Компаниудын сайн туршлага

Монгол Улсад салбарын хуулиар буюу Компанийн тухай хуулиар хараат бус дотоод аудитыг бий болгохыг хуульчилсан билээ. Иймд банкны салбарт хамгийн том болоод олон ажилтантай дотоод аудитын нэгжтэй байна. Мөн нээлттэй хувьцаат компаниудын Компанийн тухай хуулийн дагуу хараат бус дотоод аудиттай байна.

Хүснэгт 2: Үндэсний компаниудын дотоод аудитын сайн туршлага

N°	Компани	Сайн туршлага
1	МАК	▪ Бүтээгдэхүүний орцны чанар ▪ Үйлдвэрийн процессын хяналт ▪ Бүтээгдэхүүний чанарын хяналт ▪ Тус нэгжид мэргэжлийн инженерүүд ажилладаг. ▪ Гэрээ байгуулахаас өмнө саналаа өгдөг. Мөн гэрээний хэрэгжилтэд үлдэгдэл төлбөр төлөхөөс өмнө дүгнэлт гаргаж, саналаа өгдөг. ▪ Нэгж хоорондын мэдээллийн уялдааг хангахад анхаарч байна. ▪ ISO 19001 нэвтрүүлсэн. ▪ ESG стандартыг нэвтрүүлэхээр ажиллаж байна. ▪ Мэдээллийн аюулгүй байдал, дижитал шилжилт хийх
2	Эрдэнэс Монгол ХХК	▪ Нэгдлийн компаниуд эрсдэлийн удирдлагын тогтолцоог сул, ач холбогдол өгдөггүй байсны өнгөрсөн 1 жилийн хугацаанд өөрчилж, эрсдэлийн удирдлагын эрх зүйн орчныг бэхжүүлэх ажил хийгдэж байна. ▪ Нэгдлийн компаниуд 100% эрсдэлийн журам, аргачлалтай болж, эрсдэлээ үнэлдэг болж хэвшиж байна. ▪ Шийдвэр гаргах бүртгээ эрсдэлийн үнэлгээ хийж хэвших соёл руу орохыг зорьж байна. ▪ Эрдэнэс Монгол БОНЗ-ийн үнэлгээ хийлгэсэн.
3	Оюутол-гой ХХК	▪ Дотоод аудитыг Deliotte компаниар буюу аутсорсингийн гэрээгээр хийлгэдэг. ▪ Эрсдэлээ бодитой тодорхойлж, зөв үнэлж, хариу арга хэмжээ авч хэрэгжүүлсэн ажилтныг урамшуулдаг тогтолцоотой.
4	Номин холдинг ХХК	▪ Дотоод аудитын нэгж нь 2003 байгуулагдсан. 18 ажилтантай. ▪ Ажилчдын ур чадварын үнэлгээ хийж, ур чадварыг хөгжүүлэх 70:20:10 зарчим баримталдаг.

5	Монло- жистик ХХК	- Дотоод аудитын нэгж 2021 онд байгуулагдсан. 5 ажилтантай. - Шүгэл үлээх тогтолцоог бий болгосон. - Компанийн засаглалын кодекс үнэлгээгээр 3-т орсон. - Асуудалд үндсэн шалтгааны аргачлал ашигладаг. - СОСО загвар, засаглал 3 шугамын загвар
6	Хас банк	2001 онд байгуулагдсан. 17 ажилтантай. CIA 5-6 ажилтантай. - Эрсдэлд суурилсан аудит - Тасралтгүй аудитын аргачлал - Зайны аудитын аргачлал - Ажайл аудит нэвтрүүлсэн. - Спринт бүрийн төлөвлөгөө
7	Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ	2007 онд байгуулагдсан. 16 ажилтантай. - Афнор группээр үнэлгээ хийлгэсэн. - E-control - Шударга утас ажиллуулдаг.
8	Таванбогд групп ХХК	- Дотоод аудитын нэгж 12 ажилтантай. - ОУ-ын стандартад нийцүүлж ажиллаж байна. - Удирдлага нь Монголын анхны CIA зэрэгтэй. - Үйл ажиллагааны аудит, мэдээллийн технологийн аудит гэсэн үндсэн 2 чиглэлтэй. - Нягтлан бодогч, эдийн засагч, хуульч, инженер гэсэн төрөл бүрийн мэргэжлийн хүмүүсээр бүрдсэн баг ажилладаг.
9	Хаан банк ХХК	48 аудитортай. - ТУЗ дэргэдэх аудитын хорооны харьяанд ажилладаг. - Төв банкны аудит, IT аудит, салбар нэгжийн аудит гэсэн 3 бүтцээр ажилладаг. - Өнгөрсөн үйл явдлыг шалгах гэхээсээ ирээдүй рүү чиглэсэн болон тухайн цаг үед нь (Real time) аудит хийхийг зорьж байна.

Эх сурвалж: Судлаачийн тэмдэглэл

2. Дотоод аудитын чанарын судалгаа

Дотоод аудитын ажилтны үнэлгээ


(1) Дотоод аудитын нэгжийн ажиллах нөхцөлийг бүрдүүлсэн байдал, (2) дотоод аудитын ажилчдын ур чадвар, (3) дотоод аудитыг хүлээн зөвшөөрөх, дэмжих соёл тогтсон байдал, (4) дотоод аудитын нэгжийн байгууллагад оруулж буй хувь нэмэр гэсэн 4 бүлэг, 19 үзүүлэлт бүхий анкет асуулгаар компанийн аудитын ажилтнуудаас судалгаа авсан. Асуулт бүрт дараах байдлаар чанарыг үнэлсэн.

- ☐ Санал бүрэн нийлж байдал 5 оноо,
- ☐ Санал нийлбэл 4 оноо
- ☐ Эргэлзэж байвал 3 оноо
- ☐ Санал нийлэхгүй бол 2 оноо
- ☐ Огт санал 0 нийлэхгүй бол 1 оноо өгөх аргачлалаар асуултыг боловсруулсан

Судалгааг Google form хэлбэрээр болон Монголын Үндэсний дотоод аудитын холбооны 2024 оны форумд цугларсан дотоод аудитын ажилтнуудаас цаасаар бөглүүлж авсан. Судалгаанд оролцогчдоос 54 өөр компанийг төлөөлөх судалгааг сонгож авч нэгтгэн дүгнэсэн бөгөөд судалгааны дүнг нэгтгэхэд 4.3 оноотой үнэлж байна. Өөрөөр хэлбэл дотоод аудитын ажилтнууд ажлынхаа чанарыг өндрөөр үнэлж байна.

4 категори үзүүлэлтийн дундаж оноо

Зураг 4. Анкет асуулгын ерөнхий 4 бүлэг асуултын дундаж дүн




Эх сурвалж: Дотоод аудитын ажилтнуудаас авсан анкет асуулгын үр дүн

Дотоод аудитын ажилтнууд өөрийн нэгжийн байгууллагад оруулж хувь нэмрээ өндөр үнэлж байгаа бол ажилчдынхаа ур чадвар, карьер хөгжлийг хамгийн багаар үнэлсэн байна.

1.1. Дотоод аудитын нэгжийн ажиллах нөхцөлийг бүрдүүлсэн байдал

Зураг 5. Анкет асуулгын 1-р бүлгийн дундаж дүн




Эх сурвалж: Дотоод аудитын ажилтнуудаас авсан анкет асуулгын үр дүн

Ажилчид Дотоод аудитын дүрэм, хараат бусаар ажиллаж чаддаг гэдгээ өндрөөр үнэлсэн харин чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай техник санхүүгээр дэмжлэг гэдэг санал нийлдэг ч бусад үзүүлэлтүүдтэй харьцуулахад багаар үнэлсэн байна.

1.2. Дотоод аудитын ажилчдын ур чадвар, карьер хөгжил

Зураг 6. Анкет асуулгын 2-р бүлгийн дундаж дүн




Эх сурвалж: Дотоод аудитын ажилтнуудаас авсан анкет асуулгын үр дүн

Хамгийн баг үнэлгээ авсан энэхүү хэсгийг задалж харвал компани чадвартай ажилтнаа тус нэгж рүү сэлгүүлж ажиллуулдаг, дотоод аудитын нэгжийг ирээдүйн удирдлагыг сургах талбар, удирдах албан тушаалд хүрэх шат болгон ашигладаг гэдэгтэй төдий л санал хийлээгүй, эргэлзэж хариулсан байна.

1.3. Дотоод аудитыг хүлээн зөвшөөрөх, дэмжих соёл тогтсон байдал

Зураг 7. Анкет асуулгын 3-р бүлгийн дундаж дүн



Эх сурвалж: Дотоод аудитын ажилтнуудаас авсан анкет асуулгын цр дүн

Компанийн удирдлага дотоод аудитын ажлыг ойлгож, дэмждэг гэдэгтэй санал нийлж байна. Харин дотоод аудитын нэгжийн ажлыг бусад ажилтнууд ойлгож, зөвөөр хүлээн авдаг гэдэгт санал нийлэхгүй, эргэлзэж хариулсан байна.

1.4. Дотоод аудитын нэгжийн байгууллагад оруулж буй хувь нэмэр

Дотоод аудитын нэгж байгууллагын үнэ цэнийг нэмэгдүүлэхэд үүргээ хангалттай гүйцэтгэдэг гэдэг санал нийлдэг буюу 4.6 оноогоор үнэлсэн байна.

2. Компанийн бусад ажилтны үнэлгээ

Дотоод аудит, хяналтын нэгждээ ажилладаггүй бусад ажилчдаас “Та өөрийн ажиллаж буй компанийнхаа дотоод аудит, хяналтын нэгжийн байгууллагадаа

өгч буй үнэ цэнийг хэрхэн үнэлэх вэ?” гэдэг судалгаа авлаа.

- ☐ Санал бүрэн нийлж байдал 5 оноо,
- ☐ Санал нийлбэл 4 оноо
- ☐ Эргэлзэж байвал 3 оноо
- ☐ Санал нийлэхгүй бол 2 оноо
- ☐ Огт санал 0 нийлэхгүй бол 1 оноо өгөх аргачлалаар асуултыг боловсруулсан.

Судалгаанд хамрагдсан 68 компанийн 74 ажилтнаас авсан судалгаанаас мөн 54 компанийн дүнг ялгаж авсан. Дундаж дүн 3.44 буюу бусад ажилчдад нь дотоод аудитынхаа компанидаа авчирч буй үнэ цэнд эргэлздэг гэсэн дүн гарч байна. Хувийн компаниудын дундаж дүн 3.7, Төрийн компаниудын 3.2-той дундаж байна.

3. Дотоод аудитын нэгтгэсэн үзүүлэлт

Дотоод аудитын нэгдсэн үзүүлэлтүүдийг нэгтгэсэн үнэлгээ болон ашигт ажиллагааны хувьд дотоод аудитын нөлөөллийг регрессийн аргаар тооцож үзлээ. Дотоод аудитын нэгтгэсэн үзүүлэлтээр тооцвол:

$$DAI = 65\% * DAI_1 + 35\% * DAI_2$$

DAI -Дотоод аудитын чанарын нэгтгэсэн үнэлгээ

DAI_1 -Дотоод аудитын ажилтны үнэлгээ

DAI_2 -Бусад ажилтны үнэлгээ

Нийт онооны дундаж 4.02 бөгөөд хувийн компаниудын үнэлгээ 4.15, Төрийн компаниудын үнэлгээ 3.92-той байна.

Компанийн ашигт ажиллагаа ба дотоод аудитын үнэлгээг хийхдээ судалгаанд хамрагдсан компаниудаас санхүүгийн мэдээлэл нь нээлттэй хувьцаат 23, төрийн өмчит 31 нийт 54 компанийг сонгож авлаа. Тус компаниудын хөрөнгийн өгөөж ROA дунджаар 6%-тай, хувийн компани 10%, төрийн өмчит компани 3%-тай байна.

Корреляцийн шинжилгээ: Тус компанийн хөрөнгийн өгөөж (ROA), дотоод аудитын чанарын үзүүлэлт хооронд корреляцийн коэффициентийг бодоход 0.315 буюу сул эерэг хамааралтай байна.

Регрессийн шинжилгээ: Регрессийн шинжилгээг дараах хоёр таамаглалын хувьд үнэлж үзлээ.

$$ROA = a + b * \log(\text{Asset}) + c * DAI$$

$$ROA = a * DAI$$

$\log(\text{Asset})$ -Баланс дахь нийт хөрөнгийн дүнгээс натурал логарифм авсан утга

DAI - Дотоод аудитын чанарын утга

Энэхүү хоёр загварын 2 дахь нь илүү тайлбарлах чадвартай гарсан. Уг регрессийн үнэлгээгээр дотоод аудитын чанарын утга 1 нэгж функтээр өсөхөд, хөрөнгийн өгөөж 1.7 нэгж хувиар нэмэгддэг гэсэн дүн гарсан.

Дүгнэлт

Судалгаанд 54 өөр компанийн төлөөлөл бүхий дотоод аудит, хяналтын ажилтнууд оролцсон бөгөөд судалгааны дүнг нэгтгэхэд өөрсдийн дотоод аудитынхаа чанарыг өндрөөр үнэлж байна.

Ажилчид байгууллагынхаа дотоод аудитын ажиллах нөхцөлийг бүрдүүлсэн гэдэг эргэлзэлгүй санал нийлж байгаа бөгөөд Дотоод аудитын дүрэм оновчтой, хараат бусаар ажиллаж чаддаг гэж үзсэн байна. Дотоод аудитын ажилтнууд чанараа өндөр үнэлдэг ч, карьер хөгжлийн асуудал болон ажилтнуудын үнэлэмж, дэмжлэгийн соёлд эргэлзэх байдал ажиглагдаж байна. Энэ нь дотоод аудитын тогтолцоог илүү оновчтой болгох шаардлагыг харуулж байна.

Дотоод аудитын чанарын үзүүлэлт ба компанийн ашигт ажиллагааны (ROA) хооронд сул эерэг хамааралтай байгаагийн зэрэгцээ, чанарыг сайжруулснаар хөрөнгийн өгөөж нэмэгдэх боломжийг судалгааны үр дүн харуулж байна. Дотоод аудитын чанарын үзүүлэлт 1 нэгжээр өсөхөд компанийн ашигт ажиллагаа (ROA) 1.7 нэгж хувиар нэмэгддэг гэсэн тооцоо нь зөвхөн дотоод аудитын хөгжлийг дэмжих үндэслэл төдийгүй, компанийн нийт эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх арга зам болно гэдгийг харуулж байна.

Ашигласан материал

Д.Батбаяр, 2021, Дотоод аудит, 256 нүүр

А.Өнөржаргал, 2014, “Компанийн дотоод аудитын онол, арга зүйн асуудал” 133 нүүр

Дэлхийн банк, Сангийн яам, 2020, Чанарын үнэлгээний аргачлал, 106 нүүр

СЗХ, 2021, Байгууллагын хяналтын тогтолцооны гарын авлага, 23 нүүр

Catherine cheronno bett, 2014, “The relationship between effectiveness of internal audit function and financial performance of companies listed in Nairobi securities exchange. 82 pp

Nankunda sharon, 2013, Internal audit function and financial performance of public sector organizations: a case of national water and sewerage

corporation- mbarara branch, 99 pp

Төсвийн тухай хууль

Төрийн аудитын тухай хууль

Компанийн тухай хууль

Банкны тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль

Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолын хавсралт дотоод аудитын дүрэм

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр Тогтоолын хавсралтаар батлагдсан Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам

Хавсралт 1: СУДАЛГААНЫ АСУУЛТ

Батсайханы Балжинням миний бие МУИС БС-ийн магистрант. Энэхүү судалгаа нь эрдэм шинжилгээний ажилд ашиглагдах тул үнэн зөв бөглөж, эрдмийн ажлыг дэмжинэ гэдэгт итгэж байна.

А ХЭСЭГ: ДОТООД АУДИТЫН ЧИГ ҮҮРГИЙН ҮР ДҮНТЭЙ БАЙДАЛ

Асуулт	Санал нийлнэ.		Эргэлзэж байна.	Санал нийлэхгүй.	
	5	4	3	2	1
1. Дотоод аудитын нэгжийн ажиллах нөхцөлийг бүрдүүлсэн байдал					
1.1. Зорилго, чиг үүрэг, ажиллах зарчим зэргийг ойлгомжтой тодорхойлсон Дотоод аудитын дүрэм мөрдүүлж ажилладаг.	5	4	3	2	1
1.2. Дотоод аудитын нэгж нь чиг үүргээ хэрэгжүүлэхэд зохистой бүтэц, хүний нөөцтэй.	5	4	3	2	1
1.3. Чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай техник, санхүүгийн дэмжлэг үзүүлдэг.	5	4	3	2	1
1.4. Дотоод аудитын ажилтнууд холбогдох баримт бичиг, хүмүүс, эд хөрөнгөтэй ямар нэг хязгаарлалтгүйгээр танилцаж чаддаг.	5	4	3	2	1
1.5. Дотоод аудитын нэгж, ажилтнууд хараат бусаар дүгнэлт, тайлан гаргаж ажиллаж чаддаг.	5	4	3	2	1
1.6. Удирдлагын зүгээс аудитын хамраг хүрээг тодорхойгүй шалтгаанаар хязгаарласан, нууцалсан үйлдэл, эс үйлдэл гаргадаггүй.	5	4	3	2	1
2. Дотоод аудитын ажилчдын ур чадвар					
2.1. Ажилтнуудын аудит хийхэд шаардлагатай мэдлэг боловсрол, ур чадвар хангалтай.	5	4	3	2	1
2.2. Ажилтнуудад аудит хийхэд шаардлагатай тусгай ур чадвар, туршлага (залилан илрүүлэх, зөвлөх ур чадвар гэх мэт) хангалттай байдаг.	5	4	3	2	1
2.3. Удирдлагаас дотоод аудитын ажилтнуудыг сургах, хөгжүүлэхэд хангалттай дэмжлэг үзүүлдэг.	5	4	3	2	1
2.4. Компани чадвартай ажилтнаа дотоод аудитын нэгж рүү сэлгэн ажиллуулдаг.	5	4	3	2	1
2.5. Дотоод хяналтын нэгжийг ирээдүйн удирдлагыг сургах талбар, удирдах албан тушаалд хүрэх шат болгон ашигладаг.	5	4	3	2	1
2.6. Ажлыг гүйцэтгэхэд шаардагдах тусгай мэдлэг, ур чадвар дутагдах үед гаднаас мэргэжлийн тусалцаа авах боломж нээлттэй байдаг.	5	4	3	2	1

3. Дотоод аудитыг хүлээн зөвшөөрөх, дэмжих соёл тогтсон байдал					
3.1. Удирдлагаас дотоод аудитын нэгжийн ажилд ач холбогдол өгдөг, хангалттай дэмжлэг үзүүлдэг.	5	4	3	2	1
3.2. Компанийн удирдлага дотоод аудитын ажилтнуудтай тогтмол уулзах боломжийг гаргаж өгдөг.	5	4	3	2	1
3.3. Дотоод аудитын нэгжийн дарга, ажилтнуудыг байгууллагын стратегийн төлөвлөгөө, бодлогын чухал асуудал хэлэлцэх хурал, гүйцэтгэх удирдлагын хурал зэрэгт оролцуулдаг.	5	4	3	2	1
3.4. Дотоод аудитын нэгжийн удирдлагыг гүйцэтгэх удирдлагын багийн нэг гол гишүүн гэж үздэг.	5	4	3	2	1
3.5. Дотоод аудитын нэгжийн ажлыг бусад ажилтнууд тань ойлгож, зөвөөр хүлээн авдаг.	5	4	3	2	1
3.6. Удирдлага, бусад ажилтнуудаас төлөвлөгөөт аудитаас гадна дотоод аудитын нэгжийн зөвлөгөө, тусалцааг авах хүсэлт гаргадаг.	5	4	3	2	1
4. Дотоод аудитын нэгжийн байгууллагад оруулж буй хувь нэмэр					
4.1. Дотоод аудитын нэгж байгууллагын үнэ цэнийг нэмэгдүүлэхэд үүргээ хангалттай гүйцэтгэдэг.	5	4	3	2	1

Б ХЭСЭГ: НЭЭЛТТЭЙ АСУУЛТ

1. Дотоод аудитын хяналт шалгалтын үр дүнд бий болсон, компанид үнэ цэнэ авчирсан кейс бидэнтэй хуваалцахыг хүсье.

.....

.....

.....

2. Танай компанид дотоод аудитын үйл ажиллагааг сайжруулах шаардлагатай тулгамдсан асуудал

.....

.....

.....

3. Компанийн нэр /Энэ нь зөвхөн математик загвар бодоход ашиглагдах бөгөөд судалгааны ажилд компанийн нэр огт дурдагдахгүй.

.....

.....

.....

Эрдмийг ажлыг маань дэмжсэн Танд баярлалаа.

Хавсралт 2: РЕГРЕССЫН ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

Regression Statistics	
Multiple R	0.366874
R Square	0.134597
Adjusted R Square	0.115729
Standard Error	0.171766
Observations	54

ANOVA					
	df	SS	MS	F	Significance F
Regression	1	0.243201	0.243201	8.243115	0.005905
Residual	53	1.563688	0.029504		
Total	54	1.806889			

	Coefficients	Standard Error	t Stat	P-value	Lower 95%	Upper 95%	Lower 95.0%	Upper 95.0%
X Variable 1	0.016645	0.005798	2.871083	0.005867	0.005017	0.028274	0.005017	0.028274